

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2021 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2021.11.23

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Дархан-Уул аймгийг 2021 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс нэгтгэж ирүүлсэн “Дархан-Уул аймгийг 2021 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

### Гурав. Дүгнэлт

“Дархан-Уул аймгийг 2021 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний  
Нэг. Төрийн удирдлагын бодлогын хүрээнд 11 арга хэмжээ,  
Хоёр. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд 4 арга хэмжээ,  
Гурав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бодлогын хүрээнд 55 арга хэмжээ,  
Дөрөв. Нийгмийн бодлогын хүрээнд 29 арга хэмжээ, нийт 4 бодлогын хүрээнд **99** арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий үнэлгээ арга хэмжээгээр **“Үр дүнтэй”** буюу **95.95%** буюу **4.79 оноо**-гоор үнэлэгдлээ.

- “Үр дүнтэй” буюу 100% үнэлгээтэй 80 арга хэмжээ,
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90-70% үнэлгээтэй 17 арга хэмжээ,
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30% үнэлгээтэй 1 арга хэмжээ,
- “Үр дүнгүй” буюу 0% үнэлгээтэй 1 арга хэмжээ байна.

**Журмын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар илэрхийлбэл:**

№	Хяналтад авсан бодлого Арга хэмжээний үнэлгээ		Бүгд	Бодлого, арга хэмжээгээр				
				I. Төрийн удирдлагын бодлого	II. Хууль эрх зүйн бодлого	III. Хөгжлийн бодлого төлөвлөлт	IV. Нийгмийн бодлого	
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо		<b>11</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4</b>	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо		<b>99</b>	<b>11</b>	<b>4</b>	<b>55</b>	<b>29</b>	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	<b>80</b>	9	3	46	22	
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу	90.0%	<b>14</b>	2	1	7	4
			70.0%	<b>3</b>	-	-	2	1
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу	50.0%	-	-	-	-	-
			30.0%	<b>1</b>	-	-	-	1
Үр дүнгүй буюу 0.0%		<b>1</b>	-	-	-	1		
<b>Хэрэгжилтийн дундаж хувь, оноо</b>			<b>95.95% буюу 4.79 оноо</b>	<b>98.18% буюу 4.90 оноо</b>	<b>97.50% буюу 4.87 оноо</b>	<b>97.63% буюу 4.88 оноо</b>	<b>91.72% буюу 4.58 оноо</b>	

**Зорилтын хэрэгжилтийг** энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу үнэлбэл:

№	Хяналтад авсан бодлого Хяналтад авсан зорилт, үнэлгээ		Бүгд	Бодлого, зорилтоор үүнээс			
				I. Төрийн удирдлагын бодлого	II. Хууль эрх зүйн бодлого	III. Хөгжлийн бодлого төлөвлөлт	IV. Нийгмийн бодлого
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо		11	3	1	3	4
2.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	3	1	-	1	1
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99.0%	8	2	1	2	3
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31.0-69.0%	-	-	-	-	-
		Үр дүнгүй буюу 0-30.0%	-	-	-	-	-
<b>Хэрэгжилтийн дундаж хувь, оноо</b>			<b>96.35% буюу 4.81 оноо</b>	<b>97.85% буюу 4.89 оноо</b>	<b>97.50% буюу 4.75 оноо</b>	<b>98.50% буюу 4.92 оноо</b>	<b>91.57% буюу 4.57 оноо</b>

**“Эрчимжүүлэх шаардлагатай”, “0” үнэлгээтэй арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй танилцуулбал:**

№	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2021 онд хүрэх түвшин, үр дүн	2021 онд шаардлагтай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээ
A	1	2	3	4	5	6	
<b>Дөрөв. НИЙГМИЙН БОДЛОГО</b>							
<b>Зорилт:8 Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, ажилтай, орлоготой бүтээлч гэр бүлийг төлөвшүүлнэ.</b>							
76.	Алсын хараа-2050 2.3.3, МУХҮЧ 2.3.3, ЗДҮАХ 1.5.11.2	Залуучууд, Залуу гэр бүлийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ	Залуу гэр бүлийг дэмжих “Байшин” төслийг хэрэгжүүлнэ.	<b>3-аас доошгүй өрх байшинтай болсон байна.</b>	Төсөл, хөтөлбөр	Цар тахлын үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хил гааль хаагдаж барилгын материалын үнийн өсөлтөөс хамааралтайгаар 1 байшинд ногдох төсөвт өртөг 2 дахин өссөн нь төсөвлөгдсөн мөнгөн дүн хүрэлцэхгүйд хүрч 2021 онд уг төсөл хэрэгжих боломжгүй болсон	0%

Зорилт:10 Боловсрол салбарт цахим сургалт, цахим бүртгэлийг нэвтрүүлнэ							
86.	ЗГҮАХ 2.3.9, 2.3.10, 2.3.12, АХҮЧ 2.2.2 , ЗДҮАХ 1.3.2.2	Шинээр барих, өргөтгөх замаар цэцэрлэг, сургуулийн тоог нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.	960 хүүхдийн Эко сур гуулийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Барилга угсралтын ажлыг 20 хувьд хүргэнэ.	Гадаад зээл тусламж	Боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд БСШУСЯ, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа 960 суудалтай Эко сургуулийн барилгыг Дархан сумын 15 дугаар багт барихаар 2020 онд тендэр шалгаруулалт зарлахад оролцогч шалгараагүй, 2021 оны 1-р улиралд дахин зарласан боловч оролцогч ороогүйн улмаас буцсан үнэлгээний хорооноос уг төслийн төсөвт тодотгол хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарснаар 2021 оны 2-р улиралд төсөвт тодотгол хийж магадлалаар оруулсан. 2021 оны 3-р улиралд тендэр шалгаруулалт дахин зарлагдаж (2021 оны 11-р сарын 16-ны өдрийн байдлаар) Азийн хөгжлийн банкин дээр гэрээ байгуулах эрх үүсч, гүйцэтгэгчийг шалгаруулж байна. Үр дүн: 960 хүүхдийн Эко сургуулийн барилга ашиглалтад орсноор Дархан сумын 11, 12, 15 дугаар багийн хүүхэд багачууд стандартад нийцсэн анги танхимаар хангагдах боломж бүрдүүлнэ.	30.0

- Иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад бодит дэмжлэг болох 76 дугаар арга хэмжээний хувьд төсөвт өртгийг зах зээлийн үнэлгээгээр шинэчлэн, хэрэгжүүлэгч талууд (аймгийн ЗДТГ-ын НБХ, Дэлхийн зөнгийн Дархан салбар)-ын удирдах албан тушаалтнууд саналаа солилцон 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах эсэх талаар хэлэлцэх,

- 86 дугаар арга хэмжээний хувьд тайлант хугацаанд буюу Дархан-Уул аймгийн Засаг даргын 2020 оны 01-А/99, 01-А/101 дүгээр захирамжаар 1.58 га газрын асуудлыг бүрэн шийдвэрлэж, газар эзэмжих эрхийн гэрчилгээг аймгийн ГХБХБГазраас олгосон. Аймгийн БСУГ-ын барилгын хяналтын инженерийн зүгээс АХБ-ны төслийн нэгж (н.Болд-Эрдэнэ)-ийн ажилтантай байнгын холбоотой ажиллаж байна. 2021 оны жилийн эцэст үнэлгээ нэмэгдэх боломжгүй байна.

**Дөрөв. Цаашид анхаарах асуудал (Зөвлөмж)**

1. “Дархан-Уул аймгийг 2022 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г боловсруулахдаа Улсын Их хурлын 2021.07.01-ний өдрийн 56 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны

төлөвлөгөө"-тэй танилцан, аймгийн Засаг даргын хамтран хариуцахаар тусгагдсан арга хэмжээг тусгах эсэхийг судлахын зэрэгцээ арга хэмжээний зорилтот түвшинг тооцоо, судалгааны үндсэн дээр тоо болон чанараар илэрхийлж болохуйц байдлаар, шалгуур үзүүлэлтийг бодитой, хэмжиж болохуйц байдлаар, оновчтой тодорхойлох,

2. Дархан-Уул аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг бүр тухайн онд хийсэн ажлын үр дүнг 1000-2000 тэмдэгтэд багтаан бодит үр дүнг тоо баримтаар тайлагнахад онцгой анхаарч, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний багаар өөрийн үнэлгээг өгч, удирдах албан тушаалтантай танилцуулж, гарын үсгээр баталгаажуулан, хугацаанд нь аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтэстээ хүргүүлэхэд анхаарах,

3. Журмын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр үнэлэх,

4. Аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд агентлагаас ирүүлсэн хэрэгжилтэнд хийсэн ажлын үр дүнг бүрэн гүйцэт тусгасан эсэх, найруулга үг үсгийн алдааг хянах, удаашралтай арга хэмжээний шалтгаан нөхцөл, сайжруулах гарц шийдлийн саналыг тусгаж байх,

5. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс боловсруулан аймгийн ЗДТГ-ын даргаар 2021.03.30-ны өдөр батлуулсан “Зөвлөмж” (үнэлгээний арга зүй, аргачлал)-ийг бүх албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, тус хэлтэстэй эргэх холбоотой, харилцан суралцах чиглэлд санаачлагатай хамтарч ажиллах,

6. ЗГХЭГ-ын даргын 2021 оны “Дүгнэлт зөвлөмжийг хүргүүлэх тухай” Дугаар Х/647 албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, аймгийн ЗДТГ-ын даргын 2021.09.06-ны өдөр баталсан “Зөвлөмж”-ийн хүрээнд 2021 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд хийгдсэн ажлууд орон нутгийн иргэдэд хэрхэн хүрч байгаа талаар мэдээлэл боловсруулж, аймгийн иргэдэд сурталчилахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ОРЛОГЧ А.ТҮВШИНБАТ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН

